

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР 2017 ОНЫ 10-Р САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ИЛТГЭХ ХУУДАС

Сургалт, дотоод үйл ажиллагааны чиглэлээр:

2017 оны 10 дугаар сар 2-ны өдрөөс газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтэнгүүд 2 хэсэгт хуваагдан Улиастай, Алдархаан сумаас бусад сумдын хуваан авч “Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг нэвтрүүлэх хөгжүүлэх “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажилл хийгдсэнтэй холбоотойгоор газрын кадастрын мэдээллийн сангийн хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Уг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор тухайн сумын даамал бүрт тодорхой хугацаанд үүрэг даалгавар ажиллалаа.

Мөн томилолтоор ажиллах явцдаа Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан аймгийн нийт нутаг дэвсгэрийн 30 хувийн тусгай хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулж нийт 10 сумын 146 нэгж талбар бүхий газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авахаар Ашигт малтмал, газрын тосны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газарт холбогдох баримт бичгийн хамтаар хүргүүлж 8 сумын ОНТХ-тай газрыг бүртгүүллээ.

Ховд аймаг ТНС олон улсын байгууллага, Ховд их сургуулийн хамтарсан аймгуудын ГХБХБГазрын мэргэжилтнүүдийг ArcGIS програм хангамжинд чадавхижуулах 5 хоногийн сургалтанд М.Рэнчинбямба, Д.Жавзандулам нар амжилттай оролцлоо.

Мөн Увс аймагт “Бичил уул уурхайн эрх зүйн шинэчлэл” сэдэвт сургалтанд ГУХ-ны дарга Ж.Будсүрэн Цэцэн-Уул, Дөрвөлжин, Ургамал, Завханмандал сумын холбогдох мэргэжилтэн, албан тушаалтнуудын хамт оролцлоо.



2017 оны 10 дугаар сар 27-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэн “Газрын үнэлгээний бүс”, “Төлбөрийн тойрог”-ийг шинэчлэн батлах тухай журмын төсөлд албан байгууллага ажж ахуйн нэгжүүд болон иргэдийн төлөөлөл нийт 40 гаруй хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцүүллэгийг аймгийн Нутгийн удирдлагын ордны

“Иргэний танхим”-д аймгийн ИТХ-ын ажлын албатай хамтран зохион байгуулж саналын БХБЯаманд хүргүүлээ.

2017 оны 10 сарын 28-ны өдөр Монгол банкны Завхан салбарт завхан аймаг үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудтай

2017 оны 10 сарын 30-ны өдөр Нутгийн удирдлагын ордны 2 давхарын хурлын зааланд Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний эхний хувилбарын хэлэлцүүлгийг холбогдох албан байгууллагуудын удирдлага, мэргэжилтэн нарт хэлэлцүүлж саналаа тусгууллаа.



Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн чиглэлээр:

Иргэн, албан байгууллага, аж ахуй нэгжээс ирсэн албан бичиг 41, өргөдөл гомдол 17 ирснийг цаг тухайд нь хууль эрхзүйн хүрээнд шийдвэрлэн одоогийн байдлаах 9 өргөдөл хүлээгдэж байна.

Завхан аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс мэргэжлийн шинжээч томилж өгнө гэсэн 2 хүсэлтийн ирснийг газрын даргын тушаалаар мэргэжилтэн М.Рэнчинбямба, Д.Жавзандулам нарыг томилон ажиллууллаа.

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР 2017 ОНЫ 10-Р САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ИЛТГЭХ ХУУДАС

Улсын төсөв, орон нутгийн хөглийн сан, төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа барилга угсралт, их засварын ажил техник хяналтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө удирдамж гарган ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгөөр Улиастай сумын Богдын гол багт баригдаж байгаа Спорт цогцолборын барилга угсралтын ажил үргэлжилж гадна хөөсөн дулаалга, дотор засал, хаалга цонхны угсралт, гадна дотор сантехникийн ажил, цэвэр усны шугмын ажил, уурын зуухны барилга тоног

төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж ажлын явц 80%-тай явагдаж байна. Энэ онд ашиглалтанд оруулах байсан боловч усан бассейны тоног төхөөрөмжийг Хятад улсад захиалж нэмэх 15 градуст угсрах нөхцөлтэй, ашиглагч байгууллагын орон тоо, ашиглалтын зардал шийдвэрлэгдээгүйгээс гүйцэтгэгч байгууллага хойшлуулах хүсэлт гаргаж холбогдох байгууллагын хүмүүсийг хамруулсан ажлын хэсгийг объект дээр ажиллуулж хуралдуулан ашиглалтанд оруулах хугацааг нэг жилээр хойшлуулах шийдвэр гарснаар 2017.10.20-оос технологийн зогсолт хийгээд байна.

Их-Уул сумын сургуулийн 640 хүүхдийн хичээлийн байрны барилгын 1,2-р давхарын төмөр бетон каркас цутгагдаж дууссан, 3-р давхарын А,Б блокын хэв хашмал арматурчилал хийгдэж дуусан цутгалт хийгдсэн. А блок цутгах үед цаг агаар хүйтэрсэн тул хөлдөлтөөс хамгаалж, түр зогсоох арга хэмжээ авч дулаарсан үед цутгалтыг үргэлжлүүлэн дуусгасан болно. 1-р давхрын гадна өрлөгийн ажлыг 10-р сард хийж гүйцэтгэн 2017.10.25 наас технологийн зогсолт хийгээд байна.



Барилга угсралтын ажлуудад техникийн үе шатны хяналтыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж гарсан зөрчил дутагдлыг тухай бүрд нь арилгуулах арга хэмжээ аван ажиллаж байна. Барилгын тухай хуулийн 14.6 заалтын дагуу 2014 онд ашиглалтанд орсон баталгаат хугацааны барилгуудад гарсан эвдрэл гэмтэл, ашиглалтын байдалд үзлэг шалгалт хийж гүйцэтгэгч компануудад эвдрэл гэмтлийг засварлах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар эрх шилжин хийгдэж байгаа Эрдэнэхайрхан сумын цэцэрлэгийн барилгын засвар, Цагаанхайрхан сумын цэцэрлэгийн барилгын гадна хашаа, цэвэр усны шугам татах ажлыг “Боду” ХХК, Улиастай сумын Жинст багийн төв замын гэрэлтүүлгийн нэмэлт ажлыг “Идэр тэс” ХХК, Хүнс хөдөө аж ахуй

газрын засварын ажлыг “Энхмөнх ирээдүй” ХХК гүйцэтгэж улсын комисс ажилуулан ашиглалтанд орууллаа. Алдархаан сумын 75 хүүхдийн дотуур байрны их засварын ажлыг “Тэсийн бүрд” ХХК гүйцэтгэж байна. ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар эрх шилжин хийгдэж байгаа Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн их засварын ажлыг “Зуурмаг” ХХК гүйцэтгэж байна.

Цэцэн-Уул сумын сургуулийн 160 хүүхдийн хичээлийн байрны барилга угсралтын ажил 2017 оны хавар эхлэхээр байсан боловч ажлын зураг экспиртизээр баталдаагүй, мөнх цэвдэг хөрстэй зэрэг шалтгаануудын улмаас хойшлогдож 2017.10.20-оос ажлаа эхэлж буурь суурийн ажил эхлээд байна.

Иргэд аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр барьж гүйцэтгэсэн барилга байгууламжийг хүсэлтийн дагуу улсын комисс ажиллуулан дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулж байна.

Тайлан бичсэн:

Ж.Будсүрэн ГУХ-ийн дарга

Г.Ганболд БХ-ийн мэргэжилтэн

Хянасан:

Н.Эрдэнэцэцэг ГХБХБГазрын дарга

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР